



**АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Хагас жилийн эд хөрөнгийн тооллого
явуулах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.1 дэх заалт, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2022 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|---------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | М.Мөнхболд | Хангамж үйлчилгээний аж ахуйн албаны дарга |
| Нарийн бичиг: | Б.Отгонгэрэл | Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан |
| Гишүүд: | Д.Галбадрах | Инженер техникийн албаны дарга |
| | Г.Амаржаргал | Эмнэлгийн тоног төхөөрөмж инженер |
| | Ч.Хүдэрбат | Сүлжээний инженер |
| | Б.Энхсайхан | Аж ахуйн нярав, арга зүйч |
| | Г.Соёл-Эрдэнэ | Нэгдсэн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн арга зүйч |

2. Хагас жилийн тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хийж, актлах эд хөрөнгийн жагсаалтыг “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, дүнг удирдлагын багт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Мөнхболд/, нарийн бичиг /Б.Отгонгэрэл/ нарт үүрэг болгосугай.

3. Тооллого хийхтэй холбоотой бэлтгэл ажил болон, тооллого хийгдэх явцад шаардлагатай эд зүйлээр хангаж ажиллахыг нийт тасгийн эрхлэгч, арга зүйч нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан /Ө.Сүрнээ/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

